



Хэвлэлийн мэдээлэл № 19/16
ШУУД ТҮГЭЭХ
2019 оны 1-р сарын 31

Олон Улсын Валютын Сан
Вашингтон, К.Т. 20431 АНУ

ОУВС Монгол Улсад хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн зургаадугаар үнэлгээний хэлэлцүүлгийг үргэлжлүүлээ

Ажлын хэсгийн айлчлалын төгсгөлд гаргаж байгаа хэвлэлийн мэдээлэлд гишүүн оронд ажилласан ОУВС-гийн мэргэжилтнүүдийн багийн урьдчилсан үр дүнг танилцуулдаг. Энэхүү мэдэгдэлд илэрхийлсэн байр суурь нь ОУВС-гийн мэргэжилтнүүдийн байр суурь бөгөөд ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн байр суурийг илэрхийлэх албагүй юм. Энэ удаагийн ажлын хэсгийн айлчлалд үндэслэн Захирлуудын зөвлөл хуралдахгүй болно.

- Эдийн засгийн эрчимтэй өсөлт үргэлжилж, төсвийн хатуу бодлого хэрэгжүүлсэнээр төсвийн нийт тэнцэл 2018 онд ашигтай гарлаа.
- Дотоод эрэлт хэт өндөр байгаа нь гадаад валютын нөөц бүрдэлтийг хязгаарлаж байгаа тул эрх баригчид эрэлтийг багасгах арга хэмжээ авлаа. Эрх баригчид илүү хатуу бодлого хэрэгжүүлэхэд бэлэн байна.
- Банкны салбарыг эрүүлжүүлэх арга хэмжээг түргэн шуурхай хэрэгжүүлж дуусгах нь шийдвэрлэх ач холбогдолтой байна. Ингэснээр банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангагдаж, хяналт шалгалтыг зохистой хэмжээнд явуулах нөхцөл бүрдэх юм.

Ноён Жэфф Готтлийбээр ахлуулсан ОУВС-гийн ажлын хэсэг 2019 оны 1-р сарын 28-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотод ажиллаж, 2017 оны 5-р сарын 24-ний өдөр батлагдсан, гурван жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн зургаадугаар үнэлгээний яриа хэлэлцээг үргэлжлүүлэн хийлээ. Хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 314.5054 сая ЗТЭ буюу ойролцоогоор 434.4 сая ам. долларын зээлийн санхүүжилт олгогдох юм [1] (Хэвлэлийн мэдээлэл № 17/193-ийг харна уу).

Ажлын хэсгийн айлчлалыг дүгнэж, ноён Готтлийб дараах мэдэгдэлийг гаргав. Үүнд:

“Гадаад орчин, нөхцөл эдийн засгийг дэмжиж, дотоодын эрэлт огцом нэмэгдэхтэй зэрэгцээд эдийн засгийн сэргэлт үргэлжилж, өсөлт 2018 онд 6 хувиас давахаар байна. Эдийн засаг эрчимтэй өсч, төсвийн зарлага санхүүжилтийг сахилга батжуулах эрх баригчдын тууштай бодлогын ачаар хөтөлбөрийн хүрээнд тогтоосон төсвийн зорилтот үзүүлэлтүүд их хэмжээгээр давж биеллээ.

“Эдийн засаг халах нь гадаад валютын нөөцийг нэмж хуримтлуулахад саад болдог бөгөөд эдийн засгийг хэт халалтаас хамгаалах үүднээс Монголбанк бодлогын хүүг өсгөж, макро зохистой бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэн зээлийн өсөлтийг хязгаарлах шийдвэр гаргалаа. Шаардлагатай бол эрх баригчид илүү хатуу бодлого хэрэгжүүлэхэд бэлэн байна.

“Банкны салбарыг эрүүлжүүлэх нь Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн гол цөм нь юм. 2017 онд хийж гүйцэтгэсэн Активын чанарын үнэлгээний үр дүнгээр авч хэрэгжүүлэх ёстой арга хэмжээнүүд дээр ОУВС-гийн мэргэжилтнүүд Монголбанктай үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна. Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн зургаадугаар үнэлгээг хэлэлцэх ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн дараагийн хурлаас өмнө өөрийн хөрөнгийн хэмжээ нь дутагдалтай гарсан банкуудыг дахин хөрөнгөжүүлэх эсвэл бүтцийн өөрчлөлтөнд хамруулах асуудлаар эрх баригчид шийдвэртэй арга хэмжээ авах үүрэг хүлээлээ. Эрх баригчидтай хийх яриа хэлэлцээ ирэх долоо хоногуудад ОУВС-гийн төв албанаас үргэлжүүлэн хийгдэх болно.

“Ажлын хэсгийг Монгол Улсад ажиллах хугацаанд хамтран ажиллаж, үр дүнтэй яриа хэлэлцээ өрнүүлэн, зочлон хүндэтгэсэн эрх баригчдад талархал дэвшүүлье.”